



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 1/40

Баянхутаг сум

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
Төлөвлөгөөт дархлаажуулалт,
лабораторийн шинжилгээний ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.1-9.9, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 225-р тогтоол, Аймгийн засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 17-ны А/212 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулах, лабораторийн оношлон, тандах шинжилгээ хийх ажлыг 2025 оны 5 дугаар сарын 01-аас 2025 оны 11 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд зохион байгуулахыг Сац манал ХХК-ийн малын эмч (Н.Санжаадамба), Унагантуур БГБХН-ийн захирал (Ж.Гэрэлмаа), Бумансүвд гэрэл ХХК-ний малын эмч (Х.Сүвдэрдэнэ), Чандман талын тан ХХК-ний малын эмч (Ч.Зоригчулуун), Ханхар Их Арт ХХК-ний малын эмч (О.Эрдэнэбилэг) нарт үүрэг болгосугай.

Урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, тандалт шинжилгээг график хугацаанд шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг Багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

Мэргэжлийн байгууллагаас тогтоосон хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулхаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцох, хяналт тавих, тарилгын явцын мэдээ, гүйцэтгэлийн тайланг графикт хугацаанд нь холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг Тархвар зүйч (Б.Тожилсүрэн)-д үүрэг болгосугай.

Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Наранбадрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501070